



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/399

Улаанбаатар хот

Даргын шуурхай зөвлөгөөний бүрэлдэхүүнийг  
шинэчлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Иргэний нисэхийн ерөнхий газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан тус газрын даргын шуурхай зөвлөгөөний бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны А/745 дугаар тушаалын хавсралт, 2016 оны А/816 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2018 оны 17 дугаар сарын 19-ны өдрийн  
А/399 дугаар тушаалын хавсралт



Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
шуурхай зөвлөгөөний бүрэлдэхүүн

1. Тэргүүн дэд дарга
2. Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга
3. Захиргаа, удирдлагын газрын дарга
4. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
5. Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга
6. Агаарын тээврийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
7. Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газрын дарга
8. Нисэх буудлуудын удирдах газрын дарга
9. Дотоод аудитын албаны дарга
10. Ерөнхий хянагч бөгөөд ерөнхий нягтлан бодогч

----- оОо -----